# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР 2024 ОН / ХУУЛЬ, УИХ-ЫН ТОГТООЛ УИХБХ-НЫ ТОГТООЛ /

2024 оны 05 дугаар сарын 23-ны өдөр                                        Чойр хот

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ | Хэрэгжилтын явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллын үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| МУ-ын хууль | | | | | | | |
| 1 | | Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай 2003-05-30 дугаар 2003_01 | 15.2.3. бүс нутгийн хөгжилд улсын төсвөөс оруулж буй хөрөнгө оруулалт болон санхүүгийн бусад дэмжлэгийг зориулалтын нь дагуу үр ашигтай ашиглах; | Бүс нутгийн хөгжилд улсын төсвөөс оруулж буй хөрөнгө оруулалт болон санхүүгийн бусад дэмжлэгийг зориулалтын нь дагуу үр ашигтай ашиглах; | Энэ онд одоогоор Бүсчилсэн хөгжлийн төлөвлөгөөнд манай байгууллагатай холбогдон төсөвлөгдсөн хөрөнгө оруулалт байхгүй байна. | | |
| 5 | 18 | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01 | 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх. | Алба хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, ур чадварын нэмэгдүүдэд 14,273,436 мянган төгрөг, унаа хоолны хөнгөлөлтөд 9,008,000 мянган төгрөг нийт 23,281,436 мянган төгрөгийн нэмэгдэл цалин хөлсийг олгосон байна.<br><br>Төрийн захиргааны албан хаагчдад тасралтгүй ажилласаны нэг удаагийн урамшуулалд 4 албан хаагч хамрагдаж 21 сая төгрөгний мөнгөн | 100 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | урамшууллыг олгосон . Төрийн захиргаа 5, төрийн үйлчилгээний 8 албан хаагчдад 3,412.1 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдлийг сар бүр олгосон байна.<br><br>Төрийн захиргааны албан хаагчдын үр дүнг урамшууллыг үнэлж хагас жилээр урамшууллыг олгохоор төсөвт суулгасан. Төрийн захиргааны албан хаагчдын үр дүнг урамшууллыг үнэлж хагас жилээр урамшууллыг олгохоор төсөвт суулгасан. | | |
| 9 | 26 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01 | 8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт; | Төрийн аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт цахим системд байршуулах. | 2023 оны Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаанд болон санд хийсэн төрийн аудитын байгууллагын дүгнэлтийг цахим хуудас мөн шилэн дансанд хугацаанд нь байршуулж ажилласан. | 100 | |
| УИХ-ын тогтоол | | | | | | | |
| | 40 | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай 2020-05-13 Дугаар 2020 №52 | 3.1/. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх зохион байгуулалтын дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т үүрэг болгосугай: 1/Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, | Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймгийн түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгаж, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх. | Үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт 2024 онд тусгасан заалт байхгүй байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нийслэлийн түвшний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгаж, шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төлөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх; | | | | |
| 41 | | Монгол улсын 2023 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2022-11-11 Дугаар 2022 №72 | 1.2. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, зураг төсөв болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг 2023 онд шуурхай зохион байгуулах; | "Шинэ сэргэлтийн бодлого", "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, зураг төсөв болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг шуурхай зохион байгуулах | 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламжийн гүйцэтгэлийн үйл ажиллагаа төлөвлөгдөөгүй дээрх заалтын дагуу хэрэгжүүлэх ажил байхгүй байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 42 | | | 1.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; | Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; | 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламжийн гүйцэтгэлийн үйл ажиллагаа төлөвлөгдөөгүй дээрх заалтын дагуу хэрэгжүүлэх ажил байхгүй байна. | | |
| УИХ-ын байнгын хорооны тогоол | | | | | | | |
| 50 | | Ноос ноолуурын салбарт хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2021-04-06<br>Дугаар 2021 №02 ҮББХ | 4. 4. Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд төрийн албан хаагчийн болон сурагчийн дүрэмт хувцасны ноосон даавуу, драп болон сүлжмэл эдлэлийг дотоодын үйлдвэрлэлээр хангах, төрийн худалдан авалтыг нэмэгдүүлэх. | Үндэсний үйлдвэрлэлийг дэмжин дүрэмт хувцасыг дотоодын үйлдвэрлэлээс нийлүүлэх. | Байхгүй | | |
| 77 | | Чиглэл өгөх тухай<br>2023-03-28<br>Дугаар 2023№05 НББХ | 1.1.12/. "Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт заасан байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлого | Байгууллага бүр хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх.<br>, түүний боловсруулалтын талаар зөвлөмж гаргаж | Газрын даргын тушаалаар Эцэг эхийн зөвлөлийг 3 гишүүнтэйгээр томилон ажиллуулж байна.<br><br>Байгууллагын зөвлөлийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсанаар 2024 оны 3, 4 дүгээр улиралд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжүүлэх заалтын хэрэгжилтийг хангуулах хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хүүхэд хамгааллын бодлого, түүний боловсруулалтын талаар зөвлөмж гаргаж байгууллагуудад хүргүүлэх. | байгууллагуудад хүргүүлэх. | ажлууд хийгдэхээр төлөвлөн ажиллаж байна. Хугацаа болоогүй. | | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | | |
| 87 | | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-05-23 Дугаар 2018_46 | 3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн | - Бүх шатны байгууллагын гадна, дотно хаягийг хос бичгээр бичих.<br>- Гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичих.<br>Үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, идэвх санаачилгыг дэмжиж, урамшуулах. | Нийгмийн даатгалын ерөнхий газар нь салбарын хэмжээнд мэргэжлийн нэр томьёог орчуулах, толилох ажлыг зохион байгуулан эмхэтгэл гаргахаар ажлын хэсэг гарган ХНХЯ-нд хүргүүлсэн. Газрын хэвлэмэл хуудасны эх загвар, гадна болон өрөө тасалгааны хаягийг Үндэсний Монгол бичгээр хэвлүүлэн үйл ажиллагаандаа хэрэглэж эхэлсэн. Нийгмийн даатгалын хуулийн талаарх танилцуулгыг Монгол бичгээр хөрвүүлэн эмхэтгэл гарган гарын авлага болгон байршуулж 88 иргэдэд тараасан. Газрын үйл ажиллагааны хүрээнд гарч буй албан бичгийг хос бичгээр хөтлөх ажлыг зохион байгуулж эхэлсэн. Газрын алба хаагч хүмүүн бичиг сонинийг тогтмол захиалан уншиж өөрийгөө хөгжүүлдэг. Нийт албан хаагчдын 13 ажилтан буюу 100% нь Үндэсний Монгол бичгийн мэдлэг дунд болон дундаас дээш шатны мэдлэгтэй болсон. Аймгийн Насан туршийн боловсролын газрын сургагч Хонгорзулаас Цахим Монгол бичиг хичээлийг | 100 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгууллагуудад чиглэл болгосугай. | | 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 3 сарын хугацаанд ажлын 5 өдөр 2 цагаар хичээллүүлэхээр зохион байгуулан нийт албан хаагчдыг хамруулж байна.Газрын гадна болон өрөө тасалгааны хаягийг ISO стандартын дагуу монгол бичгээр хэвлүүлэн байршуулсан. | | |
| ҮАБЗ-ийн зөвлөмж | | | | | | | |
| 89 | | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58 | 1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах Тайлбар: Тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг иргүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур | Орон нутгийн төсвийн нэг хувиас доошгүй хөрөнгийг “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд зарцуулах<br>“Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх. | Сум дундын ойн ангиас хариуцуулсан талбайн модыг хуваарийн дагуу 3 удаа усаллаа. Мөн модны талбайн хог, хаягддлыг 3 удаа цэвэрлэн хашаа, хайсийг засварлан янзлах ажлыг зохион байгуулсан.<br><br>2024 оны 5 дугаар сарын байдлаар 60 модыг тарьж, ажилтан, албан хаагчдаас болон хамтын сангаас модны суулгац худалдан авахад 120000 төгрөгийг зарцуулсан. | 100 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах чиглэлээр төлөвлөн хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тусгах. | | | | |
| 95 | | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай<br>2022-07-11<br>Дугаар 2022_159 | 2.Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай. | Төрийн бүх байгууллага Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залах. | Газрын ажилтан, албан хаагчдын дунд хүндэтгэлийн ёслолыг зохион байгуулж Эзэн Богд Чингис хааны эш хөргийг газрын даргын албан тасалгаанд байрлуулан залав. | 100 | |
| | | | 3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай. | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг иргэдэд уриалах. | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж Монгол улсын иргэний бахархал төрүүлэх, хүүхэд залуучуудад таниулах зорилгоор байгууллагын 8 ажилтан хөрөг, баримилыг гэртээ залсан байна. | 100 | |
| ЗГ-ын тогтоол | | | | | | | |
| 105 | | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2022-01-05<br>Дугаар 2022_7 | 5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны | - Төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх;<br>- төрийн байгууллагын шийдвэр, албан бичиг, дүрэм, журам, заавар, | Нийгмийн даатгалын ерөнхий газар нь салбарын хэмжээнд мэргэжлийн нэр томьёог орчуулах, толилох ажлыг зохион байгуулан эмхэтгэл гаргахаар ажлын хэсэг гарган ХНХЯ-нд хүргүүлсэн.<br><br>Газрын хэвлэмэл хуудасны эх загвар, гадна болон өрөө тасалгааны хаягийг Үндэсний Монгол бичгээр хэвлүүлэн үйл ажиллагаандаа хэрэглэж эхэлсэн. Нийгмийн даатгалын хуулийн | 100 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны | стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших;<br>- төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх;<br>- төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх. | талаарх танилцуулгыг Монгол бичгээр хөрвүүлэн эмхэтгэл гарган гарын авлага болгон байршуулж 88 иргэдэд тараасан.<br><br>Газрын үйл ажиллагааны хүрээнд гарч буй албан бичгийг хос бичгээр хөтлөх ажлыг зохион байгуулж эхэлсэн.<br><br>Газрын алба хаагч хүмүүн бичиг сониниийг тогтмол захиалан уншиж өөрийгөө хөгжүүлдэг. Нийт албан хаагчдын 13 ажилтан буюу 100% нь Үндэсний Монгол бичгийн мэдлэг дунд болон дундаас дээш шатны мэдлэгтэй болсон. Аймгийн Насан туршийн боловсролын газрын сургагч Хонгорзулаас Цахим Монгол бичиг хичээлийг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 3 сарын хугацаанд ажлын 5 өдөр 2 цагаар хичээллүүлэхээр зохион байгуулан нийт албан хаагчдыг хамруулж байна.<br>Газрын гадна болон өрөө тасалгааны хаягийг ISO стандартын дагуу монгол бичгээр хэвлүүлэн байршуулсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх. | | | | |
| 106 | | Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай 2022-04-06 Дугаар 2022_139 | 1. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх асуудлын хүрээнд төрийн албан хаагчдад зориулсан “Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэх” богино хугацааны сургалтыг олон улсын тэргүүлэх шинэ дэвшилтэт арга хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулах арга хэмжээ авахыг “Удирдлагын академи” төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т болон Засгийн газрын холбогдох гишүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Алсын хараа 2050 богино хугацааны сургалтад төрийн албан хаагчдыг хамруулах. | Удирдлагын академийн мэргэшүүлэх ахлах түмшмэлийн сургалтанд 1 албан хаагч хамрагдаж төгссөн. Хүний нөөцийн судалгаагаар тус академийн мэргэшүүлэх суралтанд хамрагдах шаардлага хангасан албан хаагч байхгүй байна. | | |
| 108 | | Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар | 1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг | Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага болон | 2024 онд хэрэгжиж байгаа Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг иргэдэд | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2022-09-14<br>Дугаар 2022_340 | сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус үүрэг болгосугай. | мэргэжлийн холбоодттой хамтран зохион байгуулах. | хүргэх, сайн дурын даатгуулагчийн хамрагдалтыг нэмэгдүүлэхээр Насан туршийн боловсролын төв, багын дарга нартай хамтран ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.<br>9 сараас эхлэн ажил бүрэн хэрэгжиж дүр дүнгээ өгнө. | | |
| 114 | | Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2022-11-23<br>Дугаар 2022_419 | 3. Энэ тогтоолын 2-т заасан чиглэлийн хүрээнд орон нутгийн хэмжээнд Ажлын хэсэг байгуулж, тодорхой арга хэмжээ авч, шаардагдах эх үүсвэрийг батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг | - Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх.<br>- Орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж | - Байгууллагын үндсэн чиг үүрэг, төсөвт иргэдийг амьдрах нөхцөл боломжоор ханган ажиллах зүйл заалт байхгүй.<br><br>- Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг хуулиар тогтоодог, аж ахуй нэгж байгууллагын шимтгэлийг хөнгөлөх, чөлөөллөх дэмжин ажиллах боломжгүй. 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс нийгмийн даатгалын үйлчилгээ бүрэн цахимд шилжсэн. Иргэд, даатгуулагч, аж ахуй нэгж байгууллагад чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлж байна. | 100 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дарга нарт даалгасугай. /2. Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих чиглэлээр холбогдох хууль тогтоомжийг шинэчлэн боловсронгуй болгох арга хэмжээний цогц хөтөлбөр боловсруулж, батлуулахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт тус тус үүрэг болгосугай./ | ахуйн нэгж, байгууллагыг дэмжин ажиллах. | Нийгмийн даатгалын ерөнхий хуульд даатгуулагч нийгмийн даатгалд даатгуулах харьяалалыг заагаагүй байдаг тул аж ахуй нэгж байгууллага, иргэд хаана ч даатгуулж болно. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 4. Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар, бусад аймаг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн болон нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | - Улаанбаатар хотоос шилжин ирсэн иргэдэд дэмжлэг үзүүлэх.<br>- Салбарын хэмжээнд орон нутгийг сурталчилах арга хэмжээ зохион байгуулах. | - Улаанбаатар хотоос шилжин ирж ажиллах 2 албан хаагчдад санал тавьсан боловч хариу ирүүлээгүй байна.<br><br>- Говьсүмбэр аймгийн түүхт 30 жилийн ойн арга хэмжээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын холбогдох албан тушаалтнуудыг урьсан.<br>Мөн Буйлс цэцэглэх хавар арга хэмжээнд Нийгмийн даатгалын Ерөнхий газрын Хяналт шалгалтын багийг урин оролцуулж аймаг орон нутгаа сурталчлан ажилласан. | 100 | |
| 116 | | Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-12-07 Дугаар 2022_448 | 1.12. гүйцэтгэсэн ажлын бүтээмжийг нь харгалзан аймаг, сумын засаг захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалинг хоёр дахин хүртэл нэмэгдүүлсэн | - Төрийн захиргааны албан хаагчдын орон нутгийн нэмэгдлийг батлагдсан төсөвтөө багтаан олгох арга хэмжээ авах.<br>- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, | - Төрийн захиргааны нийт 6 албан хаагчийн орон нутгийн нэмэгдлийг сар бүр тогтмол олгож ирлээ.<br><br>- 2025 онд орон нутгийн төсвөөр хийгдэх төсөлт байгууллагын гаднах зогсоолын саналыг хүргүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br><br>- Байхгүй | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэмжээгээр тооцож, орон нутгийн нэмэгдлийг батлагдсан төсөвтөө багтаан олгох арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;<br>1.13.орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;<br>1.14.ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний хүрээнд нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийг аймаг болон сумын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрт хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулахыг аймаг, | батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавих.<br>- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний хүрээнд нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийг аймаг болон сумын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрт хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулах.<br>- Нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэнд орон байрны хөнгөлөлт үзүүлэх.<br>- Орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжийн арилжааны банкнаас авсан зээлийн хүүг 1 хувь хүртэл бууруулж олгох ажилд орон нутгийн зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлэх.<br>- Нийслэлээс орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжид бизнесээ | - Байхгүй<br>- Байхгүй<br>- Байхгүй | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | нийслэлийн Засаг дарга нарт; 1.15.нийслэлээс орон нутагт шилжин суурьшсан иргэнд жилийн 3 хувийн хүүтэй ипотекийн зээл олгох, орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжийн арилжааны банкнаас авсан зээлийн хүүг 1 хувь хүртэл бууруулж олгох ажилд орон нутгийн зүгээс шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.16.нийслэлээс орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжид бизнесээ эрхлэхэд нь зориулж газар болон холбогдох тусгай зөвшөөрөл олгох арга хэмжээг хүнд сурталгүйгээр шуурхай шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; 1.17.гадаад зээлийн хөрөнгөөр орон нутагт хэрэгжүүлсэн төсөл, | эрхлэхэд нь зориулж газар болон холбогдох тусгай зөвшөөрөл олгох арга хэмжээ авах. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөтөлбөрийн хүрээнд эргэн төлөгдөх нөхцөлтэй дамжуулан зээлдүүлэх гэрээгээр олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг Монгол Улсын 2023 оны төсөвт тусгасан дүнгээр бүрэн төлж барагдуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | | | | |
| 119 | | Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2023-02-08<br>Дугаар 2023_55 | 1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн явцтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын тухайн онд батлагдсан дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай | Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн явцтай уялдуулан санхүүжилтийг олгох. | 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламжийн гүйцэтгэлийн үйл ажиллагаа төлөвлөгдөөгүй. | | |
| 121 | | Хот, хөдөөгийн сэргэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай | 7. Шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл | Шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл | Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын газар нэртэй 1,7 сая дагачтай цахим хуудас ажиллуулж байна. Уг хуудсанд аймаг орон | 100 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2023-02-08<br>Дугаар 2023_68 | өгөх цахим платформыг үүсгэн, төрийн үйлчилгээг цахимжуулан “Цахим аймаг” болгох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам (Н.Учрал), аймгийн Засаг дарга нарт даалгасугай. | өгөх цахим хуудас ажиллуулах.<br>Төрийн үйлчилгээг цахимжуулан “Цахим аймаг” болгох арга хэмжээ авч ажиллах. | нутгаас зохион байгуулсан 19 арга хэмжээг түгээж ажиллаа.<br><br>1.Иргэн /Даатгуулагч/-д нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай тодорхойлолт, 2. НДШ төлөлтийн талаарх тодорхойлолт, 3. НДШ-ийн 50 хувийн буцаан олголт авах дансны дугаар холбох засах, 4. Ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт цахимаар гаргах заавар, 5. Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлт цахимаар гаргах заавар, 6. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах хүсэлт цахимаар гаргах заавар, 7. Сайн дурын даатгалын гэрээ байгуулах, 8. Ажил олгогчийн шимтгэл төлөлтийн лавлагаа, 9. Шимтгэл төлөлтийн тодорхойлолт, 10. Өндөр насны тэтгэвэр тогтоолтын хуудас, 11. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас, 12. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагаа, 13. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас дээрх 13 төрлийн үйлчилгээ цахим болсон. Дээрх үйлчилгээг иргэд ХУР-ДАН систем оператороор дамжуулан саадгүй авч байна.<br><br>2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2005 оноос хойш ашиглаж байсан системээс шинэ системрүү үе шаттайгаар нэвтрэн ажиллаж байна. Шинэ систем нэмэгдсэнээр Нийгмийн даатгалын үйлчилгээ цаашид бүрэн цахимжих боломжтой болж байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 123 | | Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2023-04-05<br>Дугаар 2023_120 | 2. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. | Цалингийн хэмжээ шинэчлэгдсэнтэй холбогдуулан өр авлага үүсгэлгүй ажиллах. | Монгол улсын засгийн газрын Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 128 дугаар тогтоолоор газрын даргын тушаалаар 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс цалинг шинэлэн баталж нийт албан хаагчдад батлагдсан төсөвт захирагдан олгож байна. | 100 | |
| | | Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай<br>2024-02-14<br>Дугаар 2024_62 | 2. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг гамшгаас хамгаалах алба, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.<br>(1.Өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан зудын эрсдэлийг бууруулах, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор улсын хэмжээнд засаг | | Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэн холбоотойгоор Иргэд, даатгуулагчийн хөдөлмөрийн нөхцөл тогтоох, сунгах, цуцлах Эрүүл мэндийн магадлалын зөвлөл хүнд нөхцөл байдалд байгаа/ хөдөө цасанд боогдсон/ 17 хөдөөний иргэдийн хөдөлмөрийн нөхцлийг иргэдийг байцлуулахгүйгээр цахимаар сунгаж ажилласан.<br>Мөн аймгийн шуурхай штаб дээр байгууллагын удирдлага 24 цагийн хугацаатай 4 удаа үүрэг гүйцэтгэж ажиллаа.<br>-Малчдад тусламжаар ирсэн 3 вагон буудайг газрын 13 албан хаагч бусад байгууллагуудын хамт шуудайлан машинд ачиж ажилласан. | 100 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагыг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.) | | | | |
| | | | 3.1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай: 3.1. Мал аж ахуйн салбарт үүсээд буй нөхцөл байдал, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор “Малчдадаа тусалъя аян”-ыг үндэсний хэмжээнд зохион байгуулахыг | | Өвөлжилт хүндэрсэн малчдад 200 мянган төгрөгийг хандивийг тус аянд нэгдсэн.<br><br>Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газарт хариуцан авсан өрх өөр орон нутагт отроор амьдарч байгаа талаар мэдээллийг албан бичгээр хүргүүлж өөр өрх хуваарилж өгөх хүсэлтийг хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй тул газрын албан хаагч Ган-Эрдэнийн аав Чинбаатарынд очиж хашаа хорооны цасыг цэвэрлэж ажилласан. | 100 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | | | | |
| | | | 3.3. Цасанд боогдсон зам, давааг чөлөөлөх, шар усны үерт өртөж болзошгүй малчин өрхийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Онцгой байдлын ерөнхий газар (Г.Ариунбуян), аймгийн Засаг дарга нарт, шаардлагатай хүн, хүч, техник хэрэгслийн дэмжлэг үзүүлж | | Байгууллагын хариуцан авсан Сүмбэр сумын 2 багын өрх Баярсайханых Хэнтий аймгийн нутагт оторт гарсан тул хүрч ажиллаж чадаагүй.<br><br>Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Засаг даргын тамгын газарт хариуцан авсан өрх өөр орон нутагт отроор амьдарч байгаа талаар мэдээллийг албан бичгээр хүргүүлж өөр өрх хуваарилж өгөх хүсэлтийг хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй тул газрын албан хаагч Ган-Эрдэнийн аав Чинбаатарынд очиж хашаа хорооны цасыг цэвэрлэж ажилласан. | 100 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ажиллахыг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр нарт; | | | | |
| | | Тоггоолын хавсралт өөрчлөн батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_82 | 2.. Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгоход шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. /2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш тайлагнах/ (1.“Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ыг хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.) | | Төрийн захиргааны 6, Төрийн үйлчилгээний 7 албан хаагчдад 3,412.1 мянган төгрөгийн орон нутагт ажилласаны нэмэгдлийг аймгийн төрийн сангийн хэлтсээс тооцоог нэхэмжлэн бүрэн олгож ажиллаа. | 100 | |
| | | Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай | 3. Мөнгөн урамшуулал олгоход 2024 онд шаардагдах хөрөнгийг тухайн төрийн захиргааны | | Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-д заасны дагуу шаардлага хангасан төрийн захиргааны 4 албан хаагчийн тэтгэмжийн тооцоог Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэн | 100 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2024-02-28<br>Дугаар 2024_83 | байгууллагын төсвийн захирагчийн батлагдсан төсөвт багтаан, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг төсвийн захирагч нар, Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай. (1.“Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.) | | шаардагдах хөрөнгийг шийдвэрлүүлэн 06 дугаар сард багтаан олгохоор ажиллаж байна. | | |
| | | 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл<br>2022-05-11<br>Дугаар 2022_28 | XX.7. Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, | - Тоон гарын үсэг олголтыг нэмэгдүүлэх.<br>- Тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллах. | Газрын нийт албан хаагч хувийн тоон гарын үсгээ ашиглаж хэвшсэн. Шинээр томилогдсон 2 албан хаагчийн тоон гарын үсэг ашиглах хүсэлтийг хүргүүлсэн.<br>25 Аж ах ахуй нэгжийн нягтлан бодогчдод тоон гарын үсгээр НДШ-ийн тайланг баталгаажуулах ач холбогдлыг сурталж таниулах ажлыг зохион байгууллаа. | 100 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов. | | | | |
| | | 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл 2022-10-10 Дугаар 2022_49 | XII.5.2. Байгууллагын мэдээллийн системийг “Үндэсний дата төв” УТҮГ-ын үүлэн системд байршуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагад даалгав. | Нутгийн захиргааны байгууллагын мэдээллийн системийг “Үндэсний дата төв” УТҮГ-ын үүлэн системд байршуулах. | 1.Иргэн /Даатгуулагч/-д нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тухай тодорхойлолт, 2. НДШ төлөлтийн талаарх тодорхойлолт, 3. НДШ-ийн 50 хувийн буцаан олголт авах дансны дугаар холбох засах, 4. Ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлт цахимаар гаргах заавар, 5. Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах хүсэлт цахимаар гаргах заавар, 6. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах хүсэлт цахимаар гаргах заавар, 7. Сайн дурын даатгалын гэрээ байгуулах, 8. Ажил олгогчийн шимтгэл төлөлтийн лавлагаа, 9. Шимтгэл төлөлтийн тодорхойлолт, 10. Өндөр насны тэтгэвэр тогтоолтын хуудас, 11. Тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас, 12. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны лавлагаа, 13. Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолтын хуудас дээрх 13 | 100 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төрлийн үйлчилгээ цахим болсон. Дээрх үйлчилгээг иргэд ХУР-ДАН систем оператороор дамжуулан саадгүй авч байна.<br>2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2005 оноос хойш ашиглаж байсан системээс шинэ системрүү үе шаттайгаар нэвтрэн ажиллаж байна. Шинэ систем нэмэгдсэнээр Нийгмийн даатгалын үйлчилгээ цаашид бүрэн цахимжих боломжтой болж байна. | | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | | |
| 83 | 155 | 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл<br>2022-12-07<br>Дугаар 2022_58 | XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын | төрийн байгууллагын цахим удирдлагын ERP системийг бүрэн ашиглах, албаны цахим хаягийг албан хэрэгт ашиглах | ERP системийг ашиглаж байгууллагын бүтэц, хүний нөөцийн мэдээллийг бүртгэн оруулж байна.<br>Газрын удирдах болон гүйцэтгэх болон удирдах албан хаагчдын бүртгэлийг хийж харилцан мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн.<br>ERP системийн эрхийг үүсгүүлэн нийт 9 албан хаагч албан бичиг баримтыг цахим хэлбэрээр солилцож хэвшсэн.<br>ERP системээр ирсэн бичиг 79.<br>Явуулсан бичиг 36. | 100 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | удирдлагад үүрэг болгов; | | | | |
| 88 | 160 | 2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2023-03-07 Дугаар 2023_11 | XII.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын жендэрийн салбар зөвлөл, орон нутгийн салбар хорооны дарга, Жендэрийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав. | Жендерийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх | Хүний эрхийн үндэсний комиссын Говьсүмбэр аймаг дахь төлөөлөгч Наранбаатараар 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн талаар сургалтанд 13 албан хаагч хамрагдсан. | | |
| 94 | 167 | 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл 2023-05-31 Дугаар 2023_23 | XXII.2. “Шил ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах; 2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын https://govisumber.ndaatgal.mn/?page_id=7322 цахим хуудсанд тухай бүр мэдээллийг байршуулж байна. | 100 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох мэдээлэл хариуцагч байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов: 1.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг өөрийн байгууллагын цахим хуудаст, шаардлагатай мэдээллийг нэгдсэн систем (shilen.gov.mn)-д байршуулж, тухай бүр шинэчилж ажиллах; 2.Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем (shilen.gov.mn)-д мэдээллийг шууд холбох боломжтой байдлаар өөрийн байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; 3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцах. | холбох боломжтой байдлаар байгууллагын системийн бэлэн байдлыг хангах; 3.Мэдээллийн сан, системийн хэвийн үйл ажиллагаа болон мэдээллийн үнэн зөв, алдаагүй байхад анхаарах. | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 95 | 168 | 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 25 дугаар тэмдэглэл 2023-06-14 Дугаар 2023_25 | XIII.5.2. 2. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ард иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлыг аймаг, дүүргүүдэд зохион байгуулахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ард иргэд, олон нийтэд сурталчлах. | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тэтгэврийн олон давхаргад тогтолцоонд шилжих заалтад тусгасаны дагуу 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр УИХ-ын нэгдсэн чуулганаар Нийгмийн даатгалын шинэчилсэн хуулиуд батлагдаж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлнэ.<br>Олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжих эрх зүйн орчин бүрдсэн талаар иргэд, даатгуулагч, ажил олгогч нийт 315 хүнд сурталчлан ажилласан.<br>Суурь тэтгэвэр олгох бодлого цаашид хэрэгжихээргүй болсон. | 100 | |
| 96 | 171 | 2023 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр 37 дугаар тэмдэглэл 2023-09-13 Дугаар 2023_37 | XV.1.3. Эрчим хүчний зохицуулах хорооноос баталсан дулаан хангамжийн үнэ тарифыг мөрдөөгүйгээс төсөвт байгууллагуудад үүссэн өр төлбөрийг 2024 оны улс, орон нутгийн төсөвт тусган батлуулахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав; | дулааны үнэ тарифын нэмэгдлийг төсөвт тусган батлуулж өр үүсгэлгүй ажиллах. | 2024 оны төсвийн төсөөлөлд дулааны үнийн нэмэгдлийг тусгаж, өр авлагагүй ажиллаж байна. | 100 | |
| | 175 | | XVIII.1.10. Зураг төсөл нь батлагдсан, газар эзэмших, ашиглах зөвшөөрөлтэй, инженерийн дэд бүтэц нь шийдэгдсэн | Зураг төсөл нь батлагдсан, газар эзэмших, ашиглах зөвшөөрөлтэй, инженерийн дэд бүтэц нь шийдэгдсэн | 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламжийн гүйцэтгэлийн үйл ажиллагаа төлөвлөгдөөгүй дээрх заалтын дагуу хэрэгжүүлэх ажил байхгүй байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | барилга, байгууламжийн төслийг улсын төсвөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт; | барилга, байгууламжийн төслийг улсын төсвөөр хэрэгжүүлэх санал хүргүүлэх. | | | |
| 98 | 176 | 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр 40 дүгээр тэмдэглэл 2023-10-04 Дугаар 2023_40 | 2.6. Ипотекийн зээлийг орон нутаг руу түлхүү чиглүүлэх, шилжин суурьшиж байгаа нарийн мэргэжлийн ажилтныг орон сууцаар хангах асуудлыг судлан үзэж, арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, аймгийн Засаг дарга нарт; | шилжин суурьшиж байгаа албан хаагчдын амьдрах орчин нөхцөлийг сайжруулах. Ипотекийн зээлд хамруулах. | Газрын Магадлагч эмчийн сул орон тоон дээр Улаанбаатар хотоос манай аймагт шилжин ажиллах хүсэлтийг 1 албан хаагчид санал болгосон. Хариу ирүүлээгүй байна. Зөвшөөрсөн хариу ирсэн тохиолдолд орон сууцны зээлд хамруулахаар банкуудад санал тавихаар төлөвлөөд байна.<br>Байгууллагын хэмжээнд хөдөө, орон нутгаас ажиллахаар ирж байгаа албан хаагч байхгүй байна. | 100 | |
| 103 | 188 | Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах тухай 2022-07-05 Дугаар 2022_6 | 1. 1.1. "Алсын харааа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харъяа байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах; 1.2.""Алсын хараа-2050" Монгол | "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх сургалтад албан хаагчдыг хамруулах, иргэдэд сурталчилах | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тэтгэврийн олон давхаргад тогтолцоонд шилжих заалтад тусгасаны дагуу 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр УИХ-ын нэгдсэн чуулганаар Нийгмийн даатгалын шинэчилсэн хуулиуд батлагдаж 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлнэ.<br>Олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжих эрх зүйн орчин бүрдсэн талаар иргэд, | 100 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах; | ажлыг зохион байгуулах. | даатгуулагч, ажил олгогч нийт 315 хүнд сурталчлан ажилласан.<br>Суурь тэтгэвэр олгох бодлого цаашид хэрэгжихээргүй болсон.<br>"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх сургалтад газрын 13 албан хаагчдыг хамруулсан. | | |
| 105 | 180 | “Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2023-04-17 Дугаар 2023_01 | 1.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийн ил тод болгож, тайланг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэж хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | Нээлттэй мэдээллийн ил тод болгож, тайланг нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэж хүргүүлэх. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын https://govisumber.ndaatgal.mn/?page_id=7322 цахим хуудсанд тухай бүр мэдээллийг байршуулж байна. | 100 | |

ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ О.БАЙГАЛЬСАЙХАН

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙН ДҮН

/2024 оны эхний хагас жилийн байдлаар/

| | | | Бүгд | Үүнээс | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Монгол Улсын хууль | УИХ-ын тогтоол | Улсын их хурлын байнгын хорооны тогтоол | Ерөнхийлөгчийн зарлиг | Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдааны | Засгийн газрын тогтоол | Ерөнхий сайдын захирамж | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | Засгийн газрын албан Даалгавар | Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын |
| Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо | | | **7** | 1 | 1 | 1 | 1 | 1 | - | 1 | - | 1 | - | - |
| Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо | | | **36** | 3 | 3 | 2 | 1 | 3 | - | 15 | - | 9 | - | - |
| Үүнээс | Биелсэн 100% | | **-** | 100 | - | - | 100 | 100 | - | 100 | - | 75 | - | - |
| | Хэрэгжих шатандаа | | **-** | - | - | - | - | - | - | 1 | - | 1 | - | - |
| | Үүний дотор | 70.0% | **-** | - | - | - | - | - | - | | - | - | - | - |
| | | 30.0% | **-** | - | - | - | - | - | - | | - | - | - | - |
| | Хугацаа болоогүй | | **-** | - | - | 1 | - | - | - | 1 | - | - | - | - |
| | Тасарсан | | **-** | - | - | - | - | - | - | | - | - | - | - |
| | Үүнээс | Зохион байгуулалтаас | **-** | - | - | - | - | - | - | | - | - | - | - |
| | | Хөрөнгө дутагдсанаас | **-** | - | - | - | - | - | - | | - | - | - | - |
| | Үнэлгээгүй ажил | | **11** | 1 | 3 | 1 | - | - | - | 5 | - | 1 | - | - |
| **Биелэлтийн хувь** | | | | **100** | | | **100** | **100** | **-** | **100** | **-** | **75** | | |